

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Батчулуун Ургийн овог: Хаа гүн Нэр: Амартүвшин Хүйс: Эрэгтэй Төрсөн он: 1978 он Төрсөн газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р төрөх эмнэлэг Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: [REDACTED]
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Тийм
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Үгүй
1.4	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.6	Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй

1.7	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p>
	Үгүй
1.8	<p>Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.</p>
	Үгүй

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p>
	<p>Миний бие төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшилд удирдах, гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байсан, өмгөөллийн салбарт зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа мэдлэг, туршлагадаа тулгуурлан шүүх эрх мэдлийн хөгжилд хувь нэмрээ оруулах хүсэлтэй тул Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргаж байна.</p> <p>Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д зааснаар Шүүхийн Ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зорилго бүхий шүүхийн захиргааны төв байгууллага юм.</p> <p>Хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого” дунд хугацааны зорилгод хөтөлбөр (2024-2034) батлагдсан. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг зэрэгт шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргаа, хүний нөөцийн менежментийг бүрдүүлж, тасралтгүй хөгжүүлэх, шүүхийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, дэд бүтцийг сайжруулах, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндэс суурь хангалттай хэмжээнд зохицуулагдсан тул хэрэгжилтийг хангах, жил бүр өмнө хүрсэн амжилтаа бататгах, сайжруулах чиглэлд судалгаанд суурилсан, хэрэгжих боломжтой, үр нөлөөтэй хамтын бодлогын шийдвэр гаргах зарчмыг баримталж ажиллана. Энэ хүрээнд дараах чиглэлд анхаарч ажиллана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжих <p>Шүүхийн үндсэн чиг үүрэг болох шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд шүүхийн захиргааны ажилчид нь дэмжлэг үзүүлж ажиллахаар хуульд зохицуулсан. Шүүхийн хүний нөөц тогтвортой, мэргэшсэн байх нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах шүүгчийн ажлын чанарт шууд нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг мөн тул энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллахад нь туслалцаа үзүүлэх, шүүхээр үйлчлүүлж буй иргэдэд шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд шүүхийн захиргааны ажилчид нь уялдаа</p>

холбоотой ажиллахад анхаарах ёстой.

Сүүлийн жилүүдэд шүүхийн ачаалал өссөн ч шүүгчийн орон тооны өсөлт түүнтэй дүйцэх хэмжээнд хүрээгүй талаар шүүхийн салбарын хүрээнд хөндөгдөж байна. Тухайлбал, Улсын дээд шүүхийн нийтэлсэн мэдээлэлд 2016 онд Монгол Улсад 520 шүүгч ажиллаж байсан бол 2025 оны байдлаар 516 шүүгч ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд эрүүгийн хэрэг 130 хувь, зөрчлийн хэрэг 143 хувь, иргэний хэрэг 117 хувь, захиргааны хэрэг 105 хувь буюу дунджаар 124 хувиар өссөн талаар дурдагдсан.

Ийм нөхцөлд шүүхийн захиргааны ажилтны орон тоог нэмэх боломжийг бүрдүүлэх, зөвхөн сул орон тоог нөхөхөөс гадна шүүхийн ачаалалыг бүс нутгаар гаргах, хэргийн төрөл, онцлог, хүн амын төвлөрөл, цахимжилтын хэрэгцээ, иргэдийн үйлчилгээ авах давтамж, ажилтны шилжилт хөдөлгөөн зэрэг бодит өгөгдөлд үндэслэсэн Нийслэл хотын шүүхүүдийн захиргааны ажилчдын тоог нэмэх буюу нэг шүүгчид хоёр туслах, нэг шүүх хуралдааны нарийн бичигтэй байхаар менежмент хийх боломжийг эрэлхийлэх шаардлагатай. Жишээ нь цагдаагийн байгууллага 2010 оноос судалгаа хийж, хүн ам, ажлын ачааллаас хамаарч байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулж нийслэлийн дүүргүүдэд 4000 хүн тутамд 1 хэсгийн байцаагч байх судалгааг хийж хэрэгжүүлж байсан. Учир нь нэгж ажилтанд ногдож байгаа өдөр тутмын шинжтэй ажил нь шүүгчийн ажлын ачааллыг бууруулах бус нэмэгдүүлэх болсныг харуулж байна.

Шүүхэд хянагдаж байгаа хэргийн яллагдагч, шүүгдэгч нь хэрэв цагдан хорих байранд хоригдож байгаа бол тэдгээртэй ар гэр нь очиж уулзахын тулд уулзалтын зөвшөөрлийг шүүгчээс авна. Энэ тохиолдолд ар гэр нь шүүх дээр очиж захиргааны ажилтан болох шүүгчийн туслахтай уулзахаар хүлээнэ, зөвшөөрлөө авсны дараагаар цагдан хорих байр руу явна гэх мэтээр өнөөгийн Улаанбаатар хотын замын ачаалалд иргэд хоёр байгууллагын хооронд явж чирэгдэл учирж байна. Энэ байдлыг цахимжилтаар бүрэн шийдвэрлэх боломжтой хэмээн үзэж байгаа.

Шүүхийн захиргааны ажилтны цалин хөлс, нэмэгдэл, нийгмийн баталгаа, ажлын байрны аюулгүй байдал, шатлан дэвших зарчмын тогтолцоог сайжруулах нь хүний нөөцийн тогтвортой хөгжлийн үндсэн зорилт байх ёстой. Тогтвор суурьшлыг нэмэгдүүлэхийн тулд шинээр ажилд орсон ажилтанд чиглүүлэх сургалт, менторшип хэрэгжүүлэх, албан тушаалын онцлог, ажилласан жил, ур чадварын түвшин, цахим системийн хэрэглээ, иргэдтэй харилцах үйлчилгээ, ёс зүй, стрессийн удирдлага, бичиг хэрэг, процессын ажиллагааны онцлогоор ялгаатай байдлаар сургалтыг хэрэгжүүлэх шаардлагатай. Шүүхийн ачаалал нэмэгдэж, цахимжилт өргөжиж, иргэдийн хүлээлт өсөж буй өнөөгийн нөхцөлд хүний нөөцийн бодлогыг улам мэргэжлийн, судалгаанд суурилсан, тогтвортой, иргэн төвтэй болгон шинэчлэх шаардлагатай байна.

2. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах

Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг бодитоор хангах үндсэн нөхцөлийн нэг нь шүүхийн санхүү, эдийн засгийн баталгаа юм. Шүүх хараат бус ажиллахын тулд зөвхөн эрх зүйн баталгаатай байх нь хангалтгүй бөгөөд төсөв, хүний нөөц, цалин хөлс, байр, техник хэрэгсэл, цахим систем, аюулгүй байдал, сургалт хөгжлийн хэрэгцээ нь бодитоор

хангагдсан байх шаардлагатай.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах талаар тодорхой бүрэн эрх хэрэгжүүлэхээр заасан. Тухайлбал, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, шүүхийн эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр ажиллах эрх зүйн үндэс хуульд тусгагдсан байна.

Гэвч өнөөгийн нөхцөлд шүүхийн ачаалал, хүний нөөц, цахимжилт, байр, тоног төхөөрөмж, аюулгүй байдал, үйлчилгээний чанартай уялдсан санхүүжилтийн хэрэгцээ улам нэмэгдэж байна. Шүүхийн ажлын ачаалал нэмэгдэхийн хэрээр байр, техник, программ хангамж, аюулгүй байдал, архив, бичиг хэрэг, тээврийн зардал хамт өсдөг. Сүүлийн жилүүдэд шүүхийн ачаалал өссөн ч хүний нөөцийн болон санхүүгийн баталгаа түүнтэй дүйцэхүйц хэмжээнд нэмэгдэх шаардлага бүрэн хангагдаагүй байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, шүүхийн үйлчилгээний чанар, шүүгч болон ажилтны ажлын ачаалал, иргэдийн шүүхэд итгэх итгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны цалин, нийгмийн баталгаа хараат бус байдлын түвшинд тогтвортой хамгаалагдах шаардлагатай. Шүүгчийн цалин, эдийн засгийн баталгаа нь шүүгчийн хараат бус ажиллах нөхцөлийн гол хэсэг юм. Шүүгч аливаа улс төр, эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөнөөс ангид ажиллахын тулд түүний хөдөлмөрийн үнэлэмж, амьдралын баталгаа, мэргэжлийн нэр хүндийг хамгаалсан цалин хөлсний тогтолцоо шаардлагатай.

Түүнчлэн, шүүхийн өдөр тутмын үйл ажиллагаа зөвхөн шүүгчээр хязгаарлагдахгүй захиргааны ажилтнуудын мэргэжлийн оролцооны үр дүнд шүүхийн үйлчилгээ иргэдэд хүрдэг тул шүүхийн байр, техник хэрэгслийн зардал бодитоор шийдвэрлэгдэх шаардлагатай байна. Шүүхийн үйл ажиллагаа хэвийн явагдахад шүүхийн байрны хүртээмж, шүүх хуралдааны танхим, дуу, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж, архивын өрөө, иргэдэд үйлчлэх хэсэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмж, хамгаалалт, аюулгүй байдлын орчин чухал үүрэгтэй. Улсын хэмжээнд 10 гаруй шүүх хувийн хэвшлийн байрыг түрээслэн үйл ажиллагаа явуулдаг ба шүүхийн байр стандартын бус байна. Энэ нь шүүхээр үйлчлүүлж буй иргэд, хэргийн оролцогчдын эрх ашгийг хөндөх, цаашилбал шүүхийн нэр хүнд, үйлчилгээний чанар, ажиллагааны шуурхай байдалд сөргөөр нөлөөлнө.

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Шүүх байгуулах тухай хуулиар “Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүх”-ийг дагнан байгуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэхүү шүүхийг байгуулах болсон зорилго нь хэрэг, маргааныг богино хугацаанд шуурхай шийдвэрлэх байсан юм. Одоогийн нөхцөл байдлыг харахад, Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүх үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй зэрэгцэн бусад шүүхүүдэд хуваарилагдсан байсан хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэх Эрүүгийн 170¹ хэрэг, Иргэний 3959² хэргийг хүлээн авч,

¹ https://www.judcouncil.mn/site/news_full/15097 7 дахь тал

² https://www.judcouncil.mn/site/news_full/15097 17 дахь тал

шүүхийн үйл ажиллагаа эхэлжээ. Өөрөөр хэлбэл, Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүхийн гол зорилго болох хэрэг, маргааныг богино хугацаанд шийдвэрлэх бус харин хэргийн ачааллаасаа одоог хүртэл гарч чадахгүй нөхцөл байдалд орсон гэж дүгнэхэд болохоор байна.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааг 2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр хуульчилсан боловч холбогдох хуулиуд нь эцэслэн батлагдаагүй учир энэхүү дагнасан шүүх одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байна. Энэхүү шүүхийн үйл ажиллагааг явуулахад дээр дурдсанчлан Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүхэд урьд бусад шүүхэд хуваарилагдсан байсан хэргүүдийг ачааллаар нэмэхгүй байх тал дээр арга хэмжээ авч ажиллана.

Шүүхийн төсвийг тухайн жилийн ерөнхий төсвийн боломжоос хамааралтай тогтоох бус, тухайн шүүхийн онцлог, хэрэг маргааны бодит ачаалал, иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгаатай холбон төлөвлөх шаардлагатай. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгаа нь шүүхийн байгууллагын дотоод захиргааны асуудал төдий бус, иргэн бүрийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн үндсэн баталгаа юм.

3. Шүүхийн цахимжуулалт

Иргэд, хуулийн этгээд, өмгөөлөгч, прокурор болон хэргийн оролцогчид шүүхэд хандах, нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах, хэргийн явцын мэдээлэл авах, шүүх хуралдааны тов мэдэх зэрэг үйлчилгээг цахимаар, ойлгомжтой, хүртээмжтэй авах боломжийг улам сайжруулах шаардлагатай. Үүний хүрээнд шүүхийн цахим системийг хэрэглэгчдэд ойлгомжтой, ашиглахад хялбар, нэг цонхны зарчимд нийцсэн хэлбэрээр хөгжүүлэх, иргэдэд зориулсан заавар, тусламж, лавлагааны цахим сувгийг өргөжүүлэх нь чухал байна.

Шүүхийн захиргааны ажилтнуудын баримт бичгийн цахим бүртгэл, хэргийн хөдөлгөөний хяналт, **шүүх хуралдааны товлолтын уялдаа, мэдэгдэл хүргэх систем, статистик тайлангийн автомат боловсруулалт** зэрэг чиглэлээр цахим шийдлийг улам боловсронгуй болгоход зорьж ажиллана. Практикт цаасан баримтыг цахимд оруулах, цахим баримтыг цаасан хэлбэрт буулгах зэргээр цахимжуулалтын үр нөлөөг бууруулсан механик ажиллагааг багасгаж ажилтнуудын ажлын ачааллыг бууруулахад анхаарна.

Цахим шүүн таслах ажиллагааны үндсэн зарчим, талуудын эрх тэгш байдал, мэтгэлцэх зарчим, нотлох баримт шинжлэн судлах, үнэлэх зэргийг хууль, процессын шаардлагад нийцүүлэн, хэрэг маргааны төрөл, оролцогчдын боломж, техникийн нөхцөлтэй уялдуулан зохистой хөгжүүлэх шаардлага бий. Бүх салбарт хиймэл оюуны үйл ажиллагаа нэвтэрч буйтай холбогдуулан шүүхийн салбарт хиймэл оюуныг хэрхэн ашиглах, хэрэглэх талаар эрх зүйн зохицуулалтыг яаралтай тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна. Энэ талаар Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс хэрэгжүүлж буй цахим шүүх 2.0 ажлыг дэмжиж ажиллана.

	<p>Үүний зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалалтыг өндөр түвшинд хангах ёстой. Шүүхийн мэдээлэл нь иргэний эрх, эрх чөлөө, хувийн нууц, хэрэг маргааны эмзэг мэдээлэлтэй шууд холбоотой тул шүүхийн цахим системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлыг хангах бодлогыг тогтмол шинэчилж, олон улсын сайн туршлагад нийцүүлэн хөгжүүлнэ.</p> <p>Шүүхийн цахимжилт нь нэг удаагийн техникийн шинэчлэл бус, тасралтгүй хөгжих бодлогын үйл явц байх ёстой. Иймд цахимжилтын бодлогыг богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж, хэрэгжилтийг хэмжих тодорхой шалгуур үзүүлэлттэй болгоно. Тухайлбал, цахимаар гаргасан нэхэмжлэл, хүсэлтийн тоо, хэргийн хөдөлгөөний мэдээлэл авах хугацаа, шүүхийн үйлчилгээний хэрэглэгчийн сэтгэл ханамж, шүүгч, ажилтны ачаалал буурсан байдал, системийн найдвартай ажиллагааны үзүүлэлт зэрэг хэмжигдэхүйц шалгуурыг ашиглах боломжтой.</p> <p>4. Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах</p> <p>Шүүхийн бие даасан байдлыг хангахын тулд шүүх эрх мэдлийн байгууллага хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус, өөрийн чиг үүргээ хуульд заасан хүрээнд бие даан хэрэгжүүлэх нөхцөлийг улам баталгаажуулах шаардлагатай. Үүний хүрээнд шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг улс төрийн болон бусад зохисгүй нөлөөллөөс ангид байлгах, шийдвэр гаргах үйл явцыг ил тод, хариуцлагатай, мэргэжлийн зарчимд тулгуурласан хэлбэрээр хөгжүүлэх нь чухал юм. Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бие даасан байдлыг хамгаалах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зөвхөн захиргааны байгууллагын байр сууринаас бус, харин шүүх эрх мэдлийн тогтвортой, хараат бус хөгжлийн баталгаа болох үүднээс ажиллах ёстой.</p> <p>Дээр дурдсан шүүхийн хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжиж, шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах, шүүхийн цахимжуулалт зэргийг Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн захиргааны төв байгууллага болохын хувьд шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласнаар өмнөх хүрсэн түвшинг бататган цаашид ахиулах боломж бүрдэнэ гэж харж байна.</p>
--	---

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</p> <p>Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан

таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.

1. 2025.01.13-ны өдрөөс одоог хүртэл Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот [redacted]

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Үйлчлүүлэгчид шүүхийн практикт суурилсан чанартай, мэргэжлийн түвшний хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хууль зүйн сургалт, судалгаа хийх.

Хамтран ажиллагсад:

[redacted] Монголын Хуульчдын холбооны гишүүн, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Б.Энхзаяа [redacted]
enkhzaya31@gmail.com

[redacted] БНХАУ-ын ХонгКонг Улсын “Нобль Ресорсис Лимитед”, “Нобль групп” ХХК-ийн Монгол дахь салбарын захирал [redacted]
AriunaTserenjav@thisisnoble.com/

2. 2023.05.05-ны өдрөөс одоог хүртэл Өмгөөллийн “Шинэ эргэлт партнерс” ХХК-д зөвлөх.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж, Мэйсон төв, 401 тоот.

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Эрүүгийн болон захиргааны хууль, тогтоомжийн судалгаа хийх, хууль тогтоомжийн төсөл болон гэрээний төсөл боловсруулах, хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх.

Хамтран ажиллагсад:

1.Монголын Хуульчдын холбооны гишүүн, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч [redacted]
enkhzaya31@gmail.com

3. 2021.03.15-ны өдрөөс 2022.06.06-ны өдрийг хүртэл “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн Захиргаа, гэрээ эрх зүйн асуудал хариуцсан зөвлөх.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, “Блю Скай Тауэр” оффис, 607 тоот

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Компанийн дотоод дүрэм, журам, үйл ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах бүх төрлийн гэрээний төсөл боловсруулах, санал дүгнэлт гаргах, компанийн удирдлагуудад хууль эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх.

Хамтран ажиллагсад:

[redacted] Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал [redacted]
munkhtur@mudch.gov.mn

[redacted] Хүний нөөцийн хэлтсийн дарга [redacted]

[redacted] Хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн [redacted]
munhgerele@yahoo.com

[redacted] Ахлах хуульч [redacted]

narankhuu.uyangar@gmail.com

Мэргэжилтэн
maqimql@yahoo.com

4. 2012.12.14-ний өдрөөс 2020.11.11-ний өдрийг хүртэл Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, [redacted]

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлэн мэргэшлийн үндсэн дээр зохион байгуулж удирдах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагчийн гэрээ байгуулж төсвийн гүйцэтгэлийн үр дүнг хангаж ажиллах, Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу алба хаагч нарыг томилж, чөлөөлөх.

Хамтран ажиллагсад:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын [redacted]
gchuluun0505@yahoo.com

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга [redacted]
batjavkhlan30@gmail.com

Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга [redacted]
sumya.bzd@gmail.com

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга [redacted]
s.suvderdene.mql@gmail.com

Ахлах нягтлан бодогч [redacted]
ulziiduvjir@gmail.com

Хүний нөөц, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан ахлах мэргэжилтэн [redacted]
bbattsetseq024@gmail.com

5. 2012.10.01-ний өдрөөс 2012.12.24-ний өдрийг хүртэл Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, [redacted]

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд эрх зүйн хүрээнд үүрэг хариуцлага хүлээж, бүртгэлийн ерөнхий газрын даргаас шийдвэр гаргахад нь хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн туслалцаа үзүүлэх.

Хамтран ажиллагсад:

Дэд дарга [redacted]
info@conscourt.gov.mn

Иргэний бүртгэлийн газрын дарга [redacted]
enkhtsetseq@nomun.mn/

Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн [redacted]
nyamtsetseq@mojha.gov.mn

Ахлах мэргэжилтэн [redacted]
oyunbileq@cabinet.gov.mn/

6. 2011.09.16-ны өдрөөс 2012.10.01-ний өдрийг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Б.Ширэндэвийн

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайдын эрхлэх асуудал, Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, үзэл баримтлалын төсөл боловсруулах, хянах, хууль санаачлагчаас санаачлан боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд өгөх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, хариуцсан чиглэлийн хууль тогтоомжийн төслийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тараасан асуудалд санал бэлтгэж Сайдад танилцуулах.

Хамтран ажиллагсад:

- Хууль зүйн бодлогын газрын дарга Ц.Цолмон info@conscourt.gov.mn
- Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Ч.Бат-Эрдэнэ baaqii841114@gmail.com
- Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн С.Энхцэцэг enkhtsetseg@arbitr.mn
- Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Т.Ганбаатар ganbaatar.t@mmhi.gov.mn/
- Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Л.Болдхүү l.boldkhuu@nhrcm.gov.mn/

7. 2008.04.30-ны өдрөөс 2011.09.16-ны өдрийг хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны мэргэжилтэн

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Б.Ширэндэвийн гудамж, [redacted]

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ шатанд гаргах, криминологийн судалгаа тоон мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, орон нутгийн хууль, эрх зүйн чиглэлийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, хариуцсан чиглэлийн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, санал дүгнэлт гаргах.

Хамтран ажиллагсад:

- Ажлын албаны дарга Ж.Нямдаваа mjnyamdavaa@gmail.com
- Ажлын албаны ахлах мэргэжилтэн Д.Бат- [dh_amqaa@yahoo.com/](mailto:dh_amqaa@yahoo.com)
- Ажлын албаны мэргэжилтэн Х.Сүрэнхорол surenkhorol999@gmail.com/
- Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн Хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн Д.Амараа adorisambuu@unicef.org

	<p>8. 2007-2008 онд “Бридж групп” ХХК-д хуулийн зөвлөх. Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Бридж плаза төв. Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Компанийн хөдөлмөрийн дотоод журам, холбогдох эрх зүйн баримт бичиг, хүний нөөцийн тушаал, шийдвэрийн төсөл боловсруулах, батлуулах, гэрээний төсөл боловсруулах, хянах, хуулийн зөвөлгөө өгөх. Хамтран ажиллагсад: ██████████ Захиргаа, хүний нөөцийн газрын захирал ██████████ ██████████ dashmaa2000@gmail.com ██████████ Хүний нөөцийн мэргэжилтэн ██████████ ██████████ purevdorjchogsom1023@gmail.com/ ██████████ Хуульч Т.Бямбаа ██████████ ██████████ byambaatar2017@gmail.com</p> <p>9. 2000.11.30-ны өдрөөс 2003.10.15-ны өдрийг хүртэл Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтэст хэрэг бүртгэгч. Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, ██████████ ██████████ Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан харьяалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэгт хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн шалтгалтын ажиллагаа явуулах. Хамтран ажиллагсад: ██████████ Хүүхдийн ахлах байцаагч ██████████ ██████████ tsatsralmq14477@gmail.com/ 2. Төлөөлөгч ██████████ ██████████ battogtokh_go@yahoo.com/ ██████████ Төлөөлөгч ██████████ ██████████ batbaatar@gmail.com/ ██████████ Төлөөлөгч ██████████ ██████████ amgalan4576@gmail.com 5. Төлөөлөгч ██████████ tulgaadajaa@yahoo.com/</p>
<p>3.2</p>	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>Үгүй</p>
<p>3.3</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p>

<p>1. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч (2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 3601 дугаартай өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээ олгосон.)</p> <p>2. Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч (2007 онд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан, 2014 онд Хуульчдын холбоо байгуулагдаж 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 2344 тоот хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ шинэчлэн олгосон.)</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

<p>4.1</p>	<p>Хууль зүйн өндөр мэргэшил Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. <p>Нэг. Үйл ажиллагааны нэр: Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллав. Хугацаа: 2023 оноос одоог хүртэл. Эрхэлсэн газар: Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Өмгөөллийн “Шинэ эргэлт партнерс” ХХК. Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Миний бие 2023 оноос эхлэн өөрийн мэдлэг, туршлагадаа үндэслэн Өмгөөллийн “Шинэ эргэлт партнерс” ХХК-д гэрээт зөвлөхөөр ажиллаж, хууль тогтоомжийн судалгаа, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, зарим шаардлагатай гэрээ, албан бичгийн төсөл боловсруулах чиглэлээр ажилласан. 2024 оны 12 сард Монголын Өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан өмгөөлөгчийн эрх олгох шалгалтад оролцон тэнцэж, 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан нь миний ажлын талбарт бас нэгэн шинэ хуудас нэмсэн үйл явдал болсон. 2025 оноос хойш Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай Монгол Улсын хуульд зааснаар өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө, мэргэжлийн туслалцаа үзүүлэх чиглэлээр голчлон ажиллаж, харилцагч, үйлчлүүлэгч нарын эрхийг шүүхэд төлөөлөх ажиллагааг хэрэгжүүлж байна. Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан: [Redacted Name] Хуульч, өмгөөлөгч [Redacted Address] enkhzaya31@gmail.com/</p>
-------------------	--

БНХАУ-ын ХонгКонг Улсын “Нобль Ресорсис Лимитед”, “Нобль групп”
ХХК-ийн Монгол дахь салбарын захирал Ц.Ариунчимэг
AriunaTserenjav@thisisnoble.com

Хоёр.

Үйл ажиллагааны нэр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль зохион байгуулах чиг үүрэг бүхий 10 гаруй удаагийн Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд дарга, нарийн бичгийн даргаар ажиллав.

Хугацаа: 2012 оноос 2020 оны 10 сар дуустал.

Эрхэлсэн газар: Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Сонгуулийн хороо, Баянзүрх дүүргийн сонгуулийн хороо

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Миний хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны багагүй хэсэг төрийн сонгууль зохион байгуулах, түүнд гар бие оролцож байсан ажилтай шууд холбогддог. ХЗДХЯ-нд ажиллаж байхдаа хууль санаачлагчаас санаачлан боловсруулсан бүх шатны сонгуулийн анхдагч болон шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн олон төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төсөл боловсруулж Засгийн газраар батлуулж байсан.

2012 онд Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажиллаж байхдаа Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын хамтарсан 2012 оны 143/836 дугаартай тушаалаар “Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах журам”-ыг хариуцан боловсруулж, сонгогчдын нэрийн жагсаалт дахь давхардал арилгах, иргэний бүртгэлийн мэдээлэл зөрүүтэй иргэний мэдээлэлд залруулга хийх, сонгогчийн бүртгэлийг сонгогчдын нэрийн жагсаалтаас иргэний үнэмлэхийн мэдээлэлтэй тулган шалгах үндэслэлийг тодорхой болгож байсан.

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байхдаа 2013, 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль, 2016, 2020 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгууль, нөхөн, дахин сонгууль явагдах хуулийн үндэслэл бүрдсэн тухай бүрд Нийслэл, Дүүргийн Сонгуулийн хорооны дарга, Нарийн бичгийн дарга, Гишүүнээр ажиллаж төрийн сонгуулийг түвшин явуулж, маргаан будлиангүй хуулийн дагуу зохион байгуулах, иргэний Үндсэн хуулиар баталгаажуулсан сонгох, сонгогдох эрхийг хангах үйлсэд гар бие ажиллаж ирсэн байна. Сонгууль зохион байгуулахад хүний нөөц, техник хэрэгсэл, байр, зохион байгуулалтыг өндөр түвшинд хангаж ажиллаж ирснийг үнэлэн Сонгуулийн Ерөнхий Хорооны талархал, мөнгөн шагналаар удаа дараа шагнагдаж байсан.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

1. Нийслэлийн Сонгуулийн хорооны дарга Ё.Гэрэлчулуун
gchuluun0505@yahoo.com
2. Баянзүрх дүүргийн Сонгуулийн хорооны гишүүн У.Номин-Эрдэнэ
nomin9006@yahoo.com/
3. Баянзүрх дүүргийн Сонгуулийн хорооны гишүүн Ж.Батжавхлан
batjavkhlан30@gmail.com

Дараах цахим холбоосоор Сонгуулийн хороонд томилогдож, үйл ажиллагаа явуулж байсан зарим мэдээллийг харах боломжтой.

1. <https://ikon.mn/n/q06>
2. <https://imongolia.mn/post/54469>

3. <https://ikon.mn/n/1yto>

Гурав.

Үйл ажиллагааны нэр: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллав.

Хугацаа: 2012-2013 он

Эрхэлсэн газар: Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Монгол Улс Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын үнэлгээгээр нийт 49 зөвлөмжийн 38-д “огт хэрэгжилтгүй” болон “хагас хэрэгжилттэй” гэж дүгнэгдсэн учраас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ФАТФ-ын 49 зөвлөмжийн хэрэгжилтийг шалгуулах, олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлага үүссэн. Энэ хүрээнд 2011 онд БНСУ-ын Пусан хотод болсон Ази, Номхон далайн орнуудын бүсийн хуралд оролцож цаашид авч хэрэгжүүлэх санал, хуулийн төсөлд тусгах чиглэл зэргийг томъёолсон.

Нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслөөр зарим нэр томъёог шинээр оруулж, мэдээлэх сэжигтэй гүйлгээний мөнгөн дүн, мэдээлэх арга хэлбэр, санхүүгийн гүйлгээ мэдээлэх үүрэг бүхий этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг тодорхой болгож, Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүргийг тодорхой болгож, өргөжүүлсэн. Мөн мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээн дэх эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны онцлог зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах замаар хуульчилж өгсөн. Анх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл хэлэлцэгдэж байсан нь явцын дунд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болж өргөжин, 2023 оны 05 дугаар сард УИХ-аар батлагдсан.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

■ Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга

batulzii@gmail.com

2. Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Т.Ганбаатар /утас: 9999-0919, цахим хаяг: ganbaatar.t@mmhi.gov.mn/

■ Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга Р.Чингис

Дөрөв.

Үйл ажиллагааны нэр: Ховд, Хэнтий, Архангай, Хөвсгөл аймгуудын шүүхэд “Гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг шүүгдэгчээс тусад нь шүүн таслах үйл ажиллагаанд оролцуулах цахим хуралдааны өрөө” байгуулав.

Хугацаа: 2010-2012 он

Эрхэлсэн газар: Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд ажиллаж байхдаа шүүх хуралдааны танхимд гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй гэрч, хохирогч хүүхдүүд шүүгдэгчтэй нэг өрөөнд сууж мэдүүлэг өгөх үед хуулиар хамгаалагдсан эрх нь ноцтойгоор зөрчигдөж байгааг судалгаагаар тогтоосон. Судалгааны үр дүнд шүүх хуралдааны танхимаас бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн

хохирогч хүүхдүүдийг тусгаарлан, өөр байршлаас шүүх хуралдааны танхимтай онлайнаар холбож өгч, мэдүүлэг авах, шүүх хуралдаанд оролцуулах ажиллагааг явуулах санаачилгыг гаргаж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн санд танилцуулж дэмжлэг авснаар Ховд, Хэнтий, Архангай, Хөвсгөл аймгуудын шүүхэд “Гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд, насанд хүрээгүй гэрч, хохирогч хүүхдийн өрөө”-г байгуулж цаашид Шүүхийн Ерөнхий Зөвлөл өөрийн хөрөнгөөр бусад шүүхүүдэд бий болгохоор шийдвэрлүүлж байсан.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

■ ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж. ■

[mjnyamdavaa@gmail.com/](mailto:mjnyamdavaa@gmail.com)

■ НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Амараа ■

adorjsambu@unisef.org/

Тав.

Үйл ажиллагааны нэр: Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, энэ чиглэлээр Бүгд Найрамдах Балба Улсад ажиллаж туршлага судлав.

Эрхэлсэн газар: Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба

Хугацаа: 2010-2012 он

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Хүн худалдаалахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, уг явдал гарах шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, хохирогчийг хамгаалах, эрхийг нь хангахтай холбогдсон харилцааг зөвхөн Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар бүрэн дүүрэн зохицуулах боломжгүй болсон тул Хууль зүй, дотоод хэргийн сайд 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 92 дугаар тушаалаар Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулж хуулийн төслийг боловсруулж, танилцуулах үүргийг өгсөн. Ажлын хэсэг жил орчим ажиллаж, гадаад улсуудын туршлага судлах хүрээнд 2011 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 19-ний өдрийн хооронд Бүгд Найрамдах Балба Улсад ажиллаж туршлага судалж, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн төслийг 4 бүлэг 18 зүйлтэйгээр боловсруулсан.

Хуулийн төсөлд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тусгаснаас гадна холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тайлан мэдээллийг сонсох, шалгалт явуулах, зөвлөмж гаргах, хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлөөр уламжлуулан Засгийн газарт оруулах чиг үүрэг бүхий улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх Дэд зөвлөлийн бүрэн эрхийг тусгасан. Мөн хүн худалдаалахтай тэмцэх арга, хэлбэрийг хохирогчийг хамгаалах, тэдэнд нийгмийн үйлчилгээ, туслалцаа үзүүлэх, гэрч болон уг гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, урамшуулах болон хохирлыг нөхөн төлүүлэх арга хэлбэрийг зааж, хуулийн төсөлтэй холбогдуулан нийт долоон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг хамтад нь боловсруулсан. Улмаар 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр хуулийн төсөл батлагдаж, одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

- Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга [redacted] info@conscourt.gov.mn
- ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж. [redacted] mjnyamdavaa@gmail.com
- Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Л.Болдхүү [redacted] l.boldkhuu@nhrcm.gov.mn

Зургаа.

Үйл ажиллагааны нэр: НҮБ-ын Хүүхдийн сангийн хэрэгжүүлсэн “Хүүхдэд ээлтэй хууль зүйн орчин” төслийн ажлын хэсэгт ажиллаж, Хүүхдийн хууль зүйн хорооны дүрэм, үйл ажиллагааны аргачлал боловсруулав.

Хугацаа: 2010 он

Эрхэлсэн газар: Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилго тавьж, Хүүхдэд ээлтэй хууль зүйн орчин” төсөл хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд Хүүхдийн эрхийн хуулийн хэрэгжилт, үр нөлөөг танилцуулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажилд сургагч багш, судлаачаар оролцож Монгол Улсын 21 аймагт биечлэн очиж ажилласан. Төслийн хүрээнд мөн миний бие хариуцан “Хүүхдийн хууль зүйн хорооны ажиллах журам”-ын төсөл боловсруулсан. Улмаар Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 28 тоот тушаалаар “Хүүхдийн хууль зүйн хорооны нийтлэг журам” нэртэйгээр батлагдсан. Одоо ч Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын хуульд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” нэртэйгээр бүх шатны төрийн байгууллагад орон тооны бус статустай үйл ажиллагаа явуулж байна. төслийн хүрээнд хүүхдийн эрхийн сургалтын хөтөлбөрийг хууль зүйн сургуулиудад нэвтрүүлэх, хичээлийн хөтөлбөр гаргах чиглэлээр ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллаж хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд бодит үр дүн гарсан.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан: Тухайн үед ажиллаж байсан

- ХЗДХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ч.Нарантуяа [redacted] narantuya@mojha.gov.mn
- 2. ХЗДХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Ж.Ууганбат / [redacted] uuganbat.j@titanfood.mn
- НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Амараа [redacted] adorjsambuu@unisef.org

Долоо.

Үйл ажиллагааны нэр: Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллав.

Хугацаа: 2011 он

Эрхэлсэн газар: Хууль зүй, дотоод хэргийн яам

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 02 сарын 08-ны өдрийн 25 дугаар тушаалаар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж хуулийн төсөл боловсруулсан. 2002 оны Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж баталснаас хойш цаг үеийн нөхцөл байдал, шаардлагаас шалтгаалан 2011 оныг хүртэл уг хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн гэсэн хэдий ч эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь хохирлын хэмжээ болон гэмт хэрэгт тооцох нөхцөл байдал /гипотези/ -ийг тодорхой болгох, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон түүнчлэн өөр бусад хууль шинээр батлагдсан, зарим хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор орж ирсэн. Ийнхүү Эрүүгийн хуульд баталж мөрдсөнөөс нь хойших хугацаанд зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулсан нь тухайн эрх зүйн харилцааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж болохоор байсан. Цаашид харьцангуй урт хугацаанд тогтвортой мөрдөх зарим шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг нухацтай судалгаа хийсний үндсэн оруулах хэрэгцээ, шаардлага байсаар байсан юм.

Энэхүү шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн 95 дугаар заалтад “Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн хохирлын хэмжээг тодорхой болгох, ойлгомжгүй буюу оновчгүй хэрэглэсэн зарим нэр томъёог залруулах, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцод нийцүүлэх, албан тушаалын гэмт хэргийг ялын бодлогыг чангатгах” чиглэлээр уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төсөл боловсруулахыг Засгийн газарт даалгасан тул Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тухайн цаг үед боловсруулж Засгийн газарт өргөн мэдүүлж байсан.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

■ ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан ■

■ ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга Ц.Цолмон ■

■ Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Л.Болдхүү ■

l.boldkhuu@nhrcm.gov.mn/

Найм.

Үйл ажиллагааны нэр: Кибер гэмт хэрэгтэй тэмцэх анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд хууль эрх зүйн судалгаа хийж, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Цагдаагийн академид мэргэжил дээшлүүлэв.

Хугацаа: 2009-2010 он

Эрхэлсэн газар: Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Манай улс кибер аюулгүй байдлын талаар хууль эрх зүйн орчин бүрдээгүй, үндэсний кибер халдлага, зөрчлөөс

сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байхгүй, хамтын ажиллагаа дутмаг зэргээс шалтгаалан олон улсын байгууллагуудын санал, зөвлөмжөөр кибер аюулгүй байдлын асуудлыг Эрүүгийн хуулиас тусад нь зохицуулах шаардлага үүссэн. Энэ ажлын хүрээнд Засгийн газар, ХЗДХЯ-аас санаачлан Кибер гэмт хэрэгтэй тэмцэх анхдагч хуулийн төсөл боловсруулах, судалгаа хийх ажлын хэсэгт байгуулсан. Миний бие энэхүү ажлын хэсэгт ажиллан гадаад улсуудын туршлага судлах хүрээнд 2009 оны 10 сарын 15-ны өдрөөс 11 сарын 15-ны өдөр хүртэл нэг сарын хугацаанд Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Цагдаагийн академид мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, гадаад улсуудын кибер гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг багтаасан иж бүрэн судалгааны тайлан гаргаж ажлын хэсэгт хүлээлгэн өгч ажилласан байна.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

1.ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Нямдаваа

[mjnyamdavaa@gmail.com/](mailto:mjnyamdavaa@gmail.com)

Ес.

Үйл ажиллагааны нэр: Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чиглэлээр судалгаа хийж, Монгол Улс Олон Улсын байгууллагуудаас санхүүгийн болон техникийн дэмжлэг хүртэв.

Хугацаа: 2009 он

Эрхэлсэн газар: Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх асуудалд хууль хяналтын байгууллагуудтай хамтран судалгаа хийж, цаашид энэ чиглэлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг шинэ шатанд гаргах зайлшгүй шаардлагатай гэдгийг тогтоосон. Энэхүү ажлын хүрээнд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны шинжээчдийн багийг Монгол Улсад хийх ажлын айлчлалын бэлтгэл ажлыг хангаж судалгаа, мэдээллийг танилцуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт оролцсон. НҮБ-ын Шинжээчдийн баг Монгол Улсад ажилласнаар манай улсад хар тамхи, мансууруулах бодисоос гадна хууль бус эмийн хэрэглээ, худалдаа эрсдэлтэй шатанд очсоныг тогтоож, бодлогын түвшинд онцгой анхаарах шаардлагатай гэдгийг тогтоож чадсан.

Энэ ажлын үр дүнд 2010 онд Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Бүгд Найрамдах Унгар Улсад хийсэн айлчлалынхаа хүрээнд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Вена дахь НҮБ-ын салбарын Ерөнхий захирал, Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын албаны гүйцэтгэх захирал ноён Антонио Мариа Косткатай хоёр талт уулзалт хийж мансууруулах бодис, хуурамч эм бэлдмэлийг илрүүлэх түүнчлэн манай улсын холбогдох байгууллагуудын техникийн чадавхыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлсэн. Улмаар хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль бус эмийн хэрэглээ, худалдааг зохицуулах асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого шийдвэрт тусгаснаар уг ажлыг салбарын яамдууд үргэлжлүүлэн хэрэгжүүлж иржээ.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Нямдаваа /

[mjnyamdavaa@gmail.com/](mailto:mjnyamdavaa@gmail.com)

ХЗДХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Билгүүн info@conscourt.gov.mn

3. ХЗДХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Ж.Ууганбат uuganbat.j@titanfood.mn

Арав.

Үйл ажиллагааны нэр: 21 аймаг, 9 дүүргийн бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулж, Конрад-Аденауэр сангийн “Орон нутгийн захиргааны менежментийг сайжруулах нь” төсөлд сургагч багшаар ажиллав.

Хугацаа: 2009-2012 он

Эрхэлсэн газар: Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Конрад-Аденауэр сан

Үйл ажиллагааны гол агуулга, үр дүн: 2008 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд бүрэлдсэн бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт судалгаа хийхэд улсын хэмжээнд нийт бүрэлдэхүүний 68 хувь нь шинээр сонгогдсон, томилогдсон судалгааны үр дүн гарсан. Шийдвэр гаргах эрх бүхий дээрх албан тушаалтнуудад чиглэсэн хууль тогтоомж, арга зүйн сургалт явуулах санаачилгыг миний бие гаргаж Дэлхийн банкны “Захиргааны шийдвэрийг стандартчилах” төсөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслийн хамт олонд саналаа танилцуулж дэмжигдсэнээр санхүүгийн дэмжлэг авч чадсан. Сургалтын хөтөлбөрийг МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга Б.Долгор, Зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нараар батлуулж, сургагч багш нарыг бэлтгэж, улсын хэмжээнд 3 бүсэд хувааж, нийт 700 орчим хүнд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд үндэслэлтэй шийдвэр гаргах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг амжилттай зохион байгуулсан. Уг сургалт нь тухайн цаг үедээ зөвхөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албаны ажил бус Засгийн газрын түвшинд хууль тогтоомж сурталчлах, албан хаагчдын чадавхжуулах цаг үеэ олсон оновчтой сургалт болсон юм.

ХБНГУ-ын Конрад-Аденауэр сан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран хэрэгжүүлсэн “Орон нутгийн захиргааны менежментийг сайжруулах нь” төсөлд 2010-2011 онд сургагч багшаар ажилласан. Тус төсөл нь Монгол Улсын орон нутгийн удирдлагын тогтолцооны байдалд дүн шинжилгээ хийх, түүнийг бэхжүүлэх чиглэлээр хийх шинэтгэлийн талаар санал, зөвлөмж боловсруулах, орон нутгийн захиргааны албан хаагчдыг чадавхжуулах зорилготой байсан. Миний бие тус төсөлд сургагч багшаар бэлтгэгдэн 21 аймгийн орон нутгийн удирдлага, албан хаагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах арга зүйн талаар хичээл, сургалт зааж хамтран ажилласан.

Удирдсан, хамтран ажилласан албан тушаалтан:

1. Конрад-Аденауэр сангийн суурин төлөөлөгч Йоханнес Д.Рай
2. ЗГХЭГ-ын Орон нутгийн хэлтсийн ахлах референт н.Сандаг-Очир

ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ахлах мэргэжилтэн Б.Бат-Амгалан

dh_amqaa@yahoo.com/

	<p>4. Ажлын албаны мэргэжилтэн Х.Сүрэнхорол [REDACTED] surenkhorol999@gmail.com</p>
4.2	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл -Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ. -Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ. -Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө. Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.</p> <p>1. Аймаг, Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт зориулсан хууль тогтоомж сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх бүсчилсэн сургалтын гарын авлага. 2009 он /Содпресс ХХК, Монгол Улс, [REDACTED]</p>
4.3	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ) Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>1. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч (2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 3601 дугаартай өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээ олгосон.) 2. Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч (2007 онд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан, 2014 онд Хуульчдын холбоо байгуулагдаж 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 2344 тоот хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ шинэчлэн олгосон.)</p>
4.4	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл Суралцаж төгссөн их, дээд сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эрдмийн зэрэг, цол авсан огноог бичнэ.</p> <p>1. Хууль Сахиулахын Их Сургууль, хууль зүйн магистр, 2013-2015, дипломын дугаар E20151669</p>
4.5	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн</p>

	хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Батчулуун

Өөрийн нэр: Амартүвшин

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2026 оны 05 сарын 25.

---oOo---